



**МОНГОЛ УЛСЫН
ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧИЙН
ЗАХИРАМЖ**

2015 оны 08 сарын 18 өдөр

Дугаар 45

Улаанбаатар хот

Журам батлах тухай


Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг, Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийг цагаатгасан тухай үнэмлэх олгох журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Энэхүү журмыг 2015 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга /Ж.Наранпүрэв/-д үүрэг болгосугай.
3. Уг захирамж гарсантай холбогдуулан Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2012 оны 60 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ



Ц.ЗОРИГ



Ерөнхий шүүгчийн 2015 оны
... дугаар сарын 18-ний өдрийн
... дугаар захирамжийн хавсралт

УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДЭГЧИЙГ ЦАГААТГАСАН ТУХАЙ ҮНЭМЛЭХ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай” хуулийн дагуу Улсын Дээд шүүхээс улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийг цагаатгасан тухай үнэмлэхийг олгоходоо энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Улсын Дээд шүүхээс Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийг цагаатгасан тухай олгосон үнэмлэх нь тухайн хүн улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэж цагаатгагдсан тухай үндсэн баримт болно.

Хоёр. Хэлмэгдэгчийг цагаатгасан тухай үнэмлэхийг олгох

2.1. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийг цагаатгасан тухай үнэмлэхийг гагцхүү Улсын Дээд шүүхийн тогтоолыг үндэслэн хэлмэгдэгч болон түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчид олгоно.

2.2. Хуульд заасан тохиолдолд энэхүү үнэмлэхийг анхан шатны шүүхийн шийдвэрээр хэлмэгдсэнд тооцогдсон иргэнд тухайн шүүхийн шийдвэрийг үндэслэн Улсын Дээд шүүхээс олгож болно.

2.3. Улсын Дээд шүүхээс урьд олгосон аливаа үнэмлэх энэ журмын дагуу олгосон үнэмлэхтэй адил хүчинтэй байна.

2.4. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийг цагаатгасан тухай үнэмлэхийг зөвхөн нэг удаа, нэг иргэнд олгоно. Харин тухайн хэлмэгдэгчийг цагаатгасан тухай үнэмлэхийг Улсын Дээд шүүхийн тогтоол гарах үед олгоогүй бол нөхөн олгож болно.

2.5. Үнэмлэхийг “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай” хуулийн 10 дугаар зүйлд заасан дарааллыг баримтлан хэлмэгдэгчид өөрт нь, хэлмэгдэгч нас барсан бол түүний эхнэр, нөхөрт, эдгээр хүмүүс байхгүй бол төрсөн болон үрчилж авсан хүүхэд, төрсөн эцэг, эх, ах, эгч, дүү, ач, зээд олгоно. Эдгээр иргэн өөрийгөө хэлмэгдэгчтэй төрөл, садангийн холбоотой болохоо нотолсон байна.

2.6. Орон нутагт оршин сууж байгаа иргэд цагаатгасан тухай үнэмлэхийг авах хүсэлтээ эрх бүхий байгууллагаар дамжуулан Улсын Дээд шүүхэд ирүүлж болно. Үнэмлэх авах тухай хүсэлтийг холбогдох байгууллагууд Улсын Дээд шүүхэд ирүүлэхдээ энэ журмын 2.1, 2.2-т заасан цагаатгасан шүүхийн шийдвэрээс гадна хэлмэгдэгчийн иргэний үнэмлэхийн хуулбарыг, нас барсан хэлмэгдэгчийн үнэмлэхийг авахыг хүссэн этгээд өргөдөл гаргасан бол энэ журмын 2.7-д заасан баримтыг хуулбарлан ирүүлнэ.

2.7. Үнэмлэх авах хүсэлтийг иргэд холбогдох байгууллагууд Улсын Дээд шүүхэд ирүүлэхдээ дараах бичиг баримтыг бүрдүүлсэн байна.

- 2.7.1. хүсэлт гаргагчийн өргөдөл;
- 2.7.2. иргэний үнэмлэхний хуулбар;
- 2.7.3. Тагнуулын Ерөнхий газрын архивын лавлагаа;
- 2.7.4. цагаатгасан тогтоол /магадлал/;
- 2.7.5. нэхэмжлэгч нь хэлмэгдэгчтэй садан төрлийн холбоотойг нотолсон Үндэсний төв архивын хүн амын тооллогын бүртгэлийн лавлагаа;
- 2.7.6. шүүхийн шийдвэрийг хуулбарлан ирүүлнэ.

Гурав. Үнэмлэхийн бүртгэл

3.1. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийг цагаатгасан тухай үнэмлэхийг олгосон бүртгэлийг Улсын Дээд шүүхийн Тамгын газар хөтөлнө.

3.2. Цагаатгасан үнэмлэхний дугаарыг давхардуулж олгохгүй бөгөөд нэг үнэмлэх зөвхөн нэг дугаартай байна. Үнэмлэхийн дугаарыг он харгалзахгүй үргэлжлүүлэн олгоно.

Дөрөв. Бусад зүйл

4.1. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийг цагаатгасан тухай Улсын Дээд шүүхээс олгосон үнэмлэхийг үрэгдүүлсэн тохиолдолд дараахь байдлаар дахин олгож болно.

4.1.1. урьд олгосон үнэмлэхийг үрэгдүүлсэн бол үрэгдүүлснийг нотолсон эрх бүхий байгууллага, албан тушаалтны баримт бичиг /тухайлбал сум, дүүрэг, баг, хорооны засаг даргын тодорхойлолт, гал гарсан тухай улсын байцаагчийн акт, эд зүйлээ хулгайд алдсан тухай хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн тодорхойлолт зэрэг/-ийг үндэслэн үнэмлэхийг авсан хүний өргөдлөөр дахин олгох;

4.1.2. үнэмлэх авсан иргэн өөрөө өргөдөл гаргах боломжгүй бол түүнийг төлөөлөх итгэмжлэл бүхий этгээдэд энэ журмын 4.1.1-д заасан зохицуулалт адил үйлчилэх;

4.1.3. үрэгдүүлсэн үнэмлэхийг хүчингүйд тооцуулсан тухай зарлалыг хэлмэгдэгчийн овог, нэр, үнэмлэхийн дугаартай нь төвийн өдөр тутмын аль нэг сониноор дамжуулан зарлуулсан байна. Өргөдөлд үрэгдүүлсэн үнэмлэхийг хүчингүйд тооцсоныг зарласан сонины нийтлэлийг хавсаргана.

4.2. Дахин олгогдож буй үнэмлэхийн дугаар урьд олгосон үнэмлэхийн дугаартай адил байх бөгөөд энэ талаархи тэмдэглэлийг бүртгэлд тусгана. Дахин олгож байгаа үнэмлэхийн зүүн дээд буланд “нөхөн олгов” гэсэн тэмдэглэлийг үйлдэнэ.

4.3. Орон нутагт оршин сууж байгаа иргэд цагаатгасан тухай үнэмлэхийг үрэгдүүлсэн бол дахин авах өргөдлөө эрх бүхий байгууллагаар дамжуулан Улсын Дээд шүүхэд ирүүлэхдээ энэ журмын 4.1.1, 4.1.2-т заасан шаардлагыг хангасан байна.

4.4. Үнэмлэхийг дахин олгох тухай Улсын Дээд шүүхэд ирүүлсэн өргөдөл болон хавсаргасан материалыг цагаатгалын ажил хариуцсан шинжээч эмхэтгэн хадгална.